

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/188/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Баянхонгор хот  
2025.02.25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

Ахлах аудитор

Н.Батчимэг

Утас: 88761199

Цахим хаяг: [batchimegn@audit.gov.mn](mailto:batchimegn@audit.gov.mn)

Аудитор

Д.Даваадорж

Утас: 88953144

Цахим хаяг: [davaadorjd@audit.gov.mn](mailto:davaadorjd@audit.gov.mn)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2025.02.25 № 1/52  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл

5020368

ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ







## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,280,200.0	10,109,800.0
35	БАРАА МАТЕРИАЛ	7,280,200.0	10,109,800.0
354	Хангамжийн материал	7,280,200.0	10,109,800.0
35410	Бичиг хэргийн материал	711,000.0	1,111,000.0
35420	Аж ахуйн материал	2,759,200.0	5,188,800.0
35470	Бусад хангамжийн материал	3,810,000.0	3,810,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	36,744,777.6	62,939,987.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	36,744,777.6	62,939,987.4
392	Биет хөрөнгө	36,744,777.6	62,939,987.4
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.0	10,000,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(416,666.7)	(5,416,666.7)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,669,720.0	70,627,200.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	(26,466,811.1)	(25,378,883.4)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,336,520.0	23,075,820.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,427,884.6)	(9,967,482.5)
39217	Ном	49,900.0	-
39301	Програм хангамж	880,000.0	880,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000.0)	(880,000.0)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	44,024,977.6	73,049,787.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	44,024,977.6	73,049,787.4
51	Засгийн газрын хувь оролцоо	44,024,977.6	73,049,787.4
512	Хуримтлагдсан үр дүн	44,024,977.6	73,049,787.4
51210	Өмнөх үеийн үр дүн	44,024,977.6	44,024,977.6
51220	Тайлант үеийн үр дүн	-	29,024,809.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	44,024,977.6	73,049,787.4

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	311,214,450.6	424,908,200.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,983,850.6	23,028,500.0
120	Нийтлэг татварын бус орлого	10,983,850.6	23,028,500.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	300,230,600.0	401,879,700.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	298,610,600.0	375,700,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	298,610,600.0	375,700,300.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,620,000.0	26,179,400.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,620,000.0	26,179,400.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	282,909,708.4	395,733,498.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	282,909,708.4	395,733,498.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	271,247,837.0	366,285,989.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	178,906,689.8	254,533,667.4
210101	Үндсэн цалин	102,391,082.9	140,999,811.9
210102	Нэмэгдэл	52,730,509.0	89,671,511.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,679,998.5	9,780,056.1
210104	Урамшуулал	14,105,099.4	14,082,288.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,363,338.9	31,773,968.1
210201	Тэтгэврийн даатгал	15,465,621.6	21,606,298.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,699,265.7	2,648,487.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,431,253.5	1,697,240.1
210204	Ажилгүйдлийн даатгал	357,813.4	1,164,388.4
210205	Эрүүл мэндийн даатгал	3,409,384.7	4,657,553.6
2104	Хангамж, бараа материалын зардал	20,701,100.0	21,600,000.0
210401	Бичиг хэрэг	3,736,000.0	4,600,000.0
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.0	15,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,965,100.0	2,000,000.0
2105	Нормативт зардал	313,500.0	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	313,500.0	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.0	4,000,000.0
210604	Урсгал засвар	9,000,000.0	4,000,000.0

**Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	30,680,000.0	27,000,000.0
210702	Дотоод албан томилолт	30,680,000.0	27,000,000.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,593,600.0	11,694,956.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,948,600.0	9,954,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.0	500,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	-	120,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	163,856.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	395,000.0	935,100.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,689,608.4	15,683,398.4
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,689,608.4	15,683,398.4
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	11,661,871.4	29,447,508.5
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,500,000.0	22,679,400.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	21,179,400.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.0	1,500,000.0
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	10,161,871.4	6,768,108.5
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,161,871.4	6,768,108.5
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>28,304,742.2</b>	<b>29,174,701.6</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	149,891.8
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	149,891.8
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(149,891.8)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>28,304,742.2</b>	<b>29,024,809.8</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>300,230,600.0</b>	<b>401,879,700.0</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>300,230,600.0</b>	<b>401,879,700.0</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	298,610,600.0	375,700,300.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	298,610,600.0	375,700,300.0
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,620,000.0	26,179,400.0

Аудитын код: БНА-2025/188/НА-СТА-ТШЗ

Хуудас-9



**Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,620,000.0	26,179,400.0
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>280,610,600.0</b>	<b>382,879,700.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>280,610,600.0</b>	<b>382,879,700.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>268,948,728.7</b>	<b>353,432,191.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	178,906,689.8	254,533,667.4
210101	Үндсэн цалин	102,212,110.4	140,999,811.9
210102	Нэмэгдэл	52,766,447.5	94,853,719.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,823,032.5	9,876,336.1
210104	Урамшуулал	14,105,099.4	8,803,800.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,363,338.9	31,773,968.1
210201	Тэтгэврийн даатгал	15,207,068.9	21,606,298.3
210202	Тэтгэмжийн даатгал	1,789,066.9	2,541,917.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,431,253.5	1,270,958.7
210204	Ажилгүйдлийн даатгал	357,813.4	1,270,958.7
210205	Эрүүл мэндийн даатгал	3,578,136.2	5,083,834.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,745,100.0	22,000,000.0
210401	Бичиг хэрэг	3,600,000.0	5,000,000.0
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.0	15,000,000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,145,100.0	2,000,000.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,660,000.0	5,000,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,000,000.0
210602	Тавилга	3,660,000.0	-
210604	Урсгал засвар	9,000,000.0	4,000,000.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	30,680,000.0	27,000,000.0
210702	Дотоод албан томилолт	30,680,000.0	27,000,000.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,593,600.0	13,124,556.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,893,600.0	11,383,600.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.0	500,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	-	120,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	163,856.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.0	935,100.0

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,661,871.4	29,447,508.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,500,000.0	22,679,400.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	21,179,400.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.0	1,500,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,161,871.4	6,768,108.5
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,161,871.4	6,768,108.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	19,620,000.0	19,000,000.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,620,000.0	19,000,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,620,000.0	19,000,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	19,620,000.0	19,000,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,620,000.0	19,000,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(19,620,000.0)	(19,000,000.0)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	15,720,235.4	-	15,720,235.4
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	15,720,235.4	-	15,720,235.4
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	28,304,742.2	-	28,304,742.2
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	44,024,977.6	-	44,024,977.6
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	-	-	44,024,977.6	-	44,024,977.6
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	44,024,977.6	-	44,024,977.6
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	29,024,809.8	-	29,024,809.8
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	73,049,787.4	-	73,049,787.4

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	375,700,300.0	368,932,191.5	6,768,108.5	98.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,700,300.0	368,932,191.5	6,768,108.5	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,200,300.0	367,432,191.5	6,768,108.5	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,611,800.0	254,533,667.4	5,078,132.6	98.0
210101	Үндсэн цалин	143,730,300.0	140,999,811.9	2,730,488.1	98.1
210102	Нэмэгдэл	95,197,700.0	94,853,719.5	343,980.5	99.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,880,000.0	9,876,336.1	2,003,663.9	83.1
210104	Урамшуулал	8,803,800.0	8,803,800.0	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,451,500.0	31,773,968.1	1,677,531.9	95.0
210201	Тэтгэврийн даатгал	22,747,000.0	21,606,298.3	1,140,701.7	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,676,100.0	2,541,917.4	134,182.6	95.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,338,100.0	1,270,958.7	67,141.3	95.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,338,100.0	1,270,958.7	67,141.3	95.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,352,200.0	5,083,834.9	268,365.1	95.0
2104	Хангамж, бараа материалын зардал	22,000,000.0	22,000,000.0	-	100.0
210401	Бичиг хэрэг	5,000,000.0	5,000,000.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.0	15,000,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.0	2,000,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,000,000.0	24,000,000.0	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.0	20,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	4,000,000.0	4,000,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	27,000,000.0	27,000,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	27,000,000.0	27,000,000.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,137,000.0	8,124,556.0	12,444.0	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,383,600.0	6,383,600.0	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.0	500,000.0	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.0	120,000.0	-	100.0

**Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,900.0	163,856.0	2,044.0	98.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,400.0	22,000.0	10,400.0	67.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	935,100.0	935,100.0	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,500,000.0</b>	<b>1,500,000.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,500,000.0</b>	<b>1,500,000.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.0	1,500,000.0	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>375,700,300.0</b>	<b>368,932,191.5</b>	<b>6,768,108.5</b>	<b>98.2</b>
131001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	375,700,300.0	368,932,191.5	6,768,108.5	98.2

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>26,179,400.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>26,179,400.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,000,000.0</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,000,000.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,179,400.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,179,400.0</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,179,400.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,179,400.0

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэргэжил арга зүй, зөвлөгөө өгөх замаар төсвийн сахилга батыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, хараат бус бие даасан, бодитой баталгаажуулах болон зөвлөх үйлчилгээг үзүүлдэг бөгөөд санхүүгийн хяналт шалгалт дотоод аудит гэсэн хоёр чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор санхүүгийн хяналт шалгалтын чиг үүрэг Сангийн яаманд шилжсэнтэй холбогдуулан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Санхүүгийн хяналт шалгалтын хэлтэс нь аймгийн Засаг даргын А/680 дугаар захирамжаар 11 хүний бүтэц орон тоотойгоор Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж иржээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аудитын код: БНА-2025/188/НА-СТА-ТШЗ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Дотоод хяналтын ажилтан нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба 2024 оны санхүүгийн үйл ажиллагаа, дотоод ажилд удирдамж гарган дотоод хяналтыг хийж, аудитыг хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2021.12.15-ний өдрийн А/35 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3 дах заасан УНББОУС-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,024.8 мянган төгрөг буюу 66 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,280.2	10,109.8	2,829.6
Бараа материал	7,280.2	10,109.8	2,829.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	36,744.8	62,940.0	26,195.2
Үндсэн хөрөнгө	73,936.1	104,583.0	30,646.9
Хуримтлагдсан элэгдэл	(37,191.4)	(41,643.0)	(4,451.7)

<b>Нийт хөрөнгө</b>	44,025.0	73,049.8	29,024.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	44,025.0	73,049.8	29,024.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	44,025.0	73,049.8	29,024.8

Бараа материал дансны үлдэгдэл 10,109.8 мянган төгрөг болж 2,829.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал данс 2,429.6 мянган төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 104,583,0 мянган төгрөг болж 30,646.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 99 дүгээр захирамжийн дагуу 23,028.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж үнэ төлбөргүй, төсвийн хөрөнгөөр 19,000.0 мянган төгрөгийн тавилга, аж ахуйн эд хогшил худалдан авч, Аймгийн ИТХ-ын даргын 38 дугаар захирамжаар ашиглалтын хугацаа дууссан 15 нэр төрлийн 11,381.6 мянган төгрөгийн 23 ш хөрөнгийг акталж ашиглалтаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 70,049.8 мянган төгрөг болж мянган төгрөг болж 29,024.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 29,024.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дүгээр сарын 04-ний өдрийн 17/57 дугаар тогтоолоор 400,526.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант хугацаанд 2024 оны 09 дүгээр сарын 16-ний өдрийн 21/6 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 1 удаа тодотгол хийж 375,700.3 мянган төгрөг болсон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн санхүүжилтээр тайлант онд 375,700.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж урсгал санхүүжилтээр 375,700.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 368,932.2 мянган төгрөг буюу 98.2 хувийг зарцуулж 6,788.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн хэмнэлтэд цалин, урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн 4,408.0 мянган төгрөг зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	374,200.3	367,432.2	6,768.1	98.2
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,500.0	1,500.0	0	100.0
3	Дүн	375,700.3	368,932.2	6,768.1	98.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс 26,179.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт гүйцэтгэлээр 5,000.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 21,179.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант хугацаанд худалдан авалттай холбоотой гүйцэтгэл гараагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 10-ний өдрийн 06/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 374,919.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,749.2 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 2,436.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 21 гүйлгээний 451,209.3 мянган төгрөгийн мэдээллийг 100 хувь мэдээлсэн байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын код: БНА-2025/188/НА-СТА-ТШЗ

Байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----